

Монгол орон дахь ислам шашны дахин сэргэлт, өнөөгийн байдал

Х. Батырбек

Монголын Мусульманы нийгэмлэгүүдийн Холбоо

Түлхүүр үг: ислам шашин, мечеть (сүм хийд), медресе (шашны сургууль), имам (лам), хаж мөргөл, намаз (мөргөл), ораза (мацаг барихуй), закят (шашны татвар), садака (өглөг)

1980-аад оны дунд үеэс дэлхий дахины нийгэм-улс төрийн амьдрал, олон улсын хоорондын харилцаа, ялангуяа хуучины ЗХУ-д үүсэж өрнөсөн шинэчлэл, өөрчлөн байгуулалт нь монгол оронд ихээхэн нөлөөлж монголын нийгэм тэрхүү хувьсгалт үйл явцад татагдан орж нийгмийн амьдралын бүх хүрээ өөрчлөгдөх болсон юм.

Энэ нь хүмүүсийн шашин шүтлэгийн амьдралд ч мэдрэгдэх болсон байлаа. Үүнийг эрх баригч МАХН, төрийн зүгээс анхаарч шашны талаар явуулж ирсэн хатуу бодлогоо эргэн харж зөөлрүүлж эхэлсэн байна. Энэ дагуу тухайн үеийн АИХ-ын Тэргүүлэгчдийн 10 дугаар тогтоол 1990 оны хоёрдугаар сард гарч түүнд Эрдэнэ зуу, Амарбаясгалант, Шанхын хийдийг сэргээн засварлаж сүсэгтнүүдэд үйлчлэх, түүнчлэн Баян-Өлгий аймагт исламын мечеть байгуулж ажиллуулахыг төрөөс албан ёсоор зөвшөөрч, дэмжин туслах арга хэмжээ авахыг заасан нь тухайн үед чухал алхам болсон юм (3).

Шашин шүтлэгт гарч эхэлсэн энэ үйл явц 1990 оны гуравдугаар сарын үйл явдлын дараа улам идэвхжин гүнзгийрсэн байна. Ийм таатай нөхцөл бүрэлдснээр Монголын бурхан шашины нэгэн адил казахуудын ислам шашин мөн нэгэн адил дахин сэргэж, хүн амын өргөн давхраанд нөлөөлөх болжээ. Тухайн үед Монголын бурханы шашнаас шинээр сэргэсэн ислам шашны ялгагдах нэг онцлог ялгаа бол түүний ямар нэг байгууллага, мечеть бүхий сүм хийд байгаагүй, тиймээс бүх зүйлийг цоо шинээр эхлэх шаардлагатай байсан явдал юм. Ер нь аливаа шашин шинээр үүсэх, эсвэл дахин сэргэхэд юуны өмнө шашны байгууллага, сүм хийд байгуулах явдал нэн тэргүүний зорилт болдог байна. Үүнчлэн казахын сүсэгтэн олон, хүмүүнлэгийн салбарын сэхээтнүүд юуны өмнө ислам шашны ямар нэг байгууллагыг үүсгэн байгуулах, улмаар сүм хийд барьж босгох зорилт тулгарчээ. Энэ дагуу Монгол оронд ислам шашны анхны байгууллага болох "Монголын Мусульманы нийгэмлэг" 1990 оны 10-р сард Улаанбаатар хотод байгуулагдаж тэргүүнээр нь тухайн үед Ардын Их Хурлын депутат байсан Кадарын Сайраан, Баян-Өлгий дэхь салбар зөвлөлийн тэргүүнээр А. Шакей, анхны имамаар А.Рахат нар сонгогдсон байна.

Монголын Мусульманы Нийгэмлэг нь манай оронд ислам шашин шүтдэг сүсэгтнүүдийн олон нийтийн байгууллагын статустайгаар байгуулагдсан бөгөөд гол нь Монголын мусульманчуудын шашин шүтлэгийн эрх ашгийг илэрхийлэн хэрэгжүүлэх, мечеть, шашны сургууль байгуулах, ислам шашинтай орнуудтай холбоо тогтоох, тэдгээр оронд шашны боловсон хүчин бүхий молла нарыг сургаж бэлтгэхийг гол зорилго болгож ажлаа эхэлсэн юм. Тиймээс манай оронд ислам шашин дахин сэргэж дэлгэрэхэд эл нийгмэлэг ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Монголын Мусульманы нийгэмлэг 1990-1992 онд зохион байгуулалтын нэн шаардлагатай анхны чухал арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний заримыг дурдвал 1990 онд Казахстан улсын шашны дээд сургуульд анхны дөрвөн залууг илгээн сургасан нь Х.Батырбек, М.Азатхан, О. Советхан, З. Нурлан нар байсан бөгөөд тэд хожим нь Монгол дахь ислам шашны зүтгэлтэнүүд болж эл шашны зохион байгуулалт, нийгэм-соёл, хүмүүнлэг, сургалт боловсролын үйл хэрэгт өөрсдийн хувь нэмрээ оруулсан юм.

1992 он хүртэл Баян-Өлгий аймаг, түүний сум, суурин газруудад ислам шашны зориулалтын сүм баригдаагүй байсан боловч нийт 13 сум, түүнчлэн Хөх

мойнак, Согоог сууринд анхны мөргөлийн газар баригдаж, тэдгээрийн имам, суурин ламаар хүүхэд өсвөр насандаа шашны боловсрол эзэмшсэнахмд настай сүсэгтэн, хуврагууд ажиллах болсон байна. Монгол Улсад ардчилал, шинэчлэл эхэлсэн шинэ үед ислам шашны зориулалтын анхны мечеть 1992 оны 11 дүгээр сард нээгджээ. Эл сүм нь Монгол Улс дахь ислам шашны төв бөгөөд бусад сүм хийдийн шашин мөргөлийн болон бусад үйл ажиллагааг удирдан зохицуулж байдаг. Тэр нь Абу Бакир Сыддых Хазретийн нэрэмжит бөгөөд түүнийг Пакистан гаралтай Англи улсын иргэн Исмайл Бухудда гэдэг хүн тухайн үеийн төгрөгийн ханшаар 6 сая төгрөгөөр санхүүжүүлэн бариулсан байна. Түүнчлэн Монголын бурхны шашны төв Гандантэгчилэн хийдээс хандив болгож 1,5 сая төгрөгийн хандив өгчээ. Мөн Шейх Мухаммад Хамданы ивээн тэтгэлэг, хандивын мөнгөөр Алтанцөгц, Бугат, Буянт, Согоог, Улаанхус, Сагсай сумдад ислам шашны зориулалтын сүм баригдсан байна.

1990 оноос хойшхи үед Монгол Улсын Баян-Өлгий, Ховд, Увс, Орхон, Дархан, Хэнтий, Налайх, Төв аймаг, Нийслэл Улаанбаатар хотод Монголын Мусульманы Нийгэмлэгийн харьяа салбар мечеть бүхий сүм хийд нийтдээ 33 байгаагийн зэрэгцээ зарим нийгэмлэг, холбоо, хувь хүмүүсээс барьж байгуулсан мечеть 5, бүгд 38 мечеть үйл ажиллагаа явуулж байна.

Монголын Мусульманы Нийгэмлэг, Өлгий хот дахь төв хийдийн зүгээс зохиож ирсэн ажил, арга хэмжээний чухал чиглэл, зорилтын нэг бол Саудын Араб улсын Мекка хот дахь дэлхийн мусульманчуудын ариун шүтээн болох Кагбад жилд нэг удаа их мөргөл үйлдэх шашны ариун үүрэг бүхий зан үйл хажьд казахын мөргөлчдийг зохион байгуулалттайгаар оролцуулах явдал юм. Энэ дагуу хаж мөргөлд монголын казах сүсэгтэнүүдэс 1989 онд Монгол Улсаас анх удаа К.Сайраан, 1991 онд 2, 1992 онд 19, 1994 онд 9, 1995 онд 2, 1998 онд 9, 2000 онд 8, 2001 онд 15, 2002 онд 15, 2003 онд 21, 2004 онд 32, 2006 онд 31, нийт 11 удаагийн их мөргөлд бүгд хоёр зуугаад сүсэгтэн очиж мөргөл үйлдэн ислам шашны хажь мөргөл үйлдсэн нь Монгол оронд ислам шашин уламжлалт ёс жаягаараа сэргэж улам бүр чөлөөтэй дэлгэрч байгаагийн илэрхийлэл болж байна.

Монголын Мусульманы Нийгэмлэг, төв хийдээс зохиож буй шашин номын өөр нэг чухал арга хэмжээ бол Ислам шашинтай томоохон орнуудад шавь хүүхэд, залуучуудыг илгээж шашны дунд, дээд сургуульд суралцуулан шашны орчин үеийн эрдэм номтой молла, имам нарыг бэлтгэж буй явдал юм. Тэдгээр хүүхэд, залуус шашны боловсролын зэрэгцээ инженер, эдийн засагч, компьютерийн программист, менежер, анагаах ухаан гэх зэрэг мэдлэг мэргэжлийн салбаруудаар иргэний дээд боловсрол эзэмшин ирж байна. 1990-2006 онд нийт 970 гаруй залуус ислам шашинт оронд суралцаж шашны болон иргэний боловсрол эзэмшжээ.

Монголын Мусульманы Нийгэмлэг, төв болон сумдад буй сүм хийдийн зүгээс ислам шашины баяр, ёслол, зан үйл хийгээд иргэний сүсэг бишрэл, нийгэм-соёл, хүмүүнлэгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн олон талтай үйл ажиллагаа явуулж үйлчилгээ үзүүлж байна. Тухайлбал ислам шашны нэгэн чухал зан үйл, ёслол болох сүннет буюу эрэгтэй хүүхдийн хөвч хөндөх зан үйлийг 1990 оноос хойш жил бүр зохион байгуулж, мэргэжлийн эмч, эмнэлгийн үйлчилгээ, тусалцаатайгаар гүйцэтгэж байна. Тухайлбал 2003-2006 он буюу сүүлийн 4 жилд нийт 4348 хүүхдэд хөвч хөндөх зан үйлийн үйлчилгээ үзүүлжээ.

Монголын Мусульманы Нийгэмлэг, сүм хийдүүд ислам шашны гол баяр болох Ид Аль-Адха буюу хажьын их мөргөл өндөрлөсний дараа болдог малаар тахил өргөх баяр ёслол, Ид аль-фитр буюу мусульманы цаг тооны бичгийн 10 дугаар сард болдог мацаг барих, тэр нь өндөрлөсний дараа болдог баяр

ёслолыг нийт сүсэгтэн мусульманчуудын дунд зохион байгуулж , тэмдэглэн өнгөрүүлж байна.

Сүм хийдүүд ислам шашны мөргөл буюу ас-салат \намаз мөргөл \, Баасан гариг бүрийн хамтын мөргөл (жума намаз), нас барагсадыг оршуулах зан үйл , сүсэгтэнүүдийн ном, мөргөл хийгээд нийгмийн эмзэг бүлэг, ядуус, өнчин, бэлэвсэн, тахир дутуу иргэдэд хандив өгөх , туслах зэрэг үйлчилгээг тогтмол зохион байгуулж байгаа юм.

Монголын Мусульманы Нийгэмлэг, сүм хийдүүдээс тогтмол зохион явуулж буй үйл ажиллагаа, арга хэмжээний нэгэн томоохон чиглэл бол шашны сургалт боловсрол эзэмшүүлэх явдал мөн. Монголын казахуудын дунд ислам шашны уламжлалт боловсрол эзэмшсэн молла, имам нарын үе 1930- аад онд тасарсан, тиймээс ислам шашны сэргэлт, сүсэгтэнүүдийн эрэлт хэрэгцээний дагуу тэдэнд шашны анхан шатны мэдлэг олгох, Коран судрыг араб үсэг, араб хэлээр уншиж сурахад нь туслах зорилгоор шашны сургалт, түр курс, хичээл зохион байгуулж түүнд олон мянган хүүхэд, залуус, сүсэгтэн иргэд хамрагдсан байна

Дэлхийн улс орнуудад шашин шүтлэгийн төлөв байдал, түвшин, хувьсалын үйл явцыг социологийн тодорхой судалгаа, тухайлбал шашны социологоор судлан танин мэддэг туршлага өргөн дэлгэрч тогтжээ. Манай орны хүн ам социализмын үед үндсэндээ шашингүйн үзэл зонхилсон шинжтэй байсныг тухайн үед манай шашин судлагч эрдэмтэд С.Пүрэвжав, Т.Содномдаргиа, Р.Вандангомбо, Г.Гэндэнсүрэн нарын хийсэн судалгаанаас харж болно(6). Манай казах иргэдийн шүтлэгийн байдал ч гэсэн ерөнхийдөө тийм шинж төрхтэй байлаа.Манай оронд тийнхүү шашингүйн үзэл зонхилж байсан тэр үеэс одоо нийтээрээ шахуу шүтлэгтэн, сүсэгтэн болж хувирсан 17 жил орчмын хугацаанд хүмүүсийн шүтлэг бишрэлийн байдал гэнт, огцом өөрчлөгдөж өнөөгийн түвшинд хүрсэн гэж үзэх аргагүй юм. Тэдний сүсэг бишрэл аажим өөрчлөгдөж өнөөгийн төлөв байдлыг олсон нь манай шашин судлагч эрдэмтэдийн 1990 оноос хойш хийсэн зарим судалгаанаас харагдаж байна.

Монголын казах иргэд, сүсэгтнүүд Коран судрыг уламжлал болгож эртний араб хэл дээр уншин шүтэж ирсэн бөгөөд шашны боловсрол эзэмшсэн тусгай молла нараас бусад жирийн хүмүүс түүний утга агуулга, казах хэлээр чухам юуны тухай өгүүлсэн байгааг мэдэхгүй иржээ. Харин 1990 оны эхэн үеэс Коран судрыг орчин үеийн казах хэлээр хөрвүүлэн нийтэлж олны дунд түгээх болсон юм. Энэ нөхцөлд урьд өмнө Коран судрыг араб хэлээр зөвхөн үгчлэн цээжилж утга агуулга, юуны тухай өгүүлсэнийг мэдэхгүй ирсэн иргэд түүнийг казах хэлээр уншиж танилцахад сэтгэл санаа, итгэл үнэмшил, үзэл бодлын хувьд зөрчилтэй, эргэлзээтэй, Коран сударт сүсэглэн итгэх, үл итгэх хоёрдмол шинжтэй болж байсан тал бий.

Ислам шашны сүсэгтнүүдэд номлож шаарддаг зан үйлийн нэг бол мусульман хүн хөрөнгө чинээ, ашиг орлогоосоо ядуу зүдүү, өнчин өрөөсөн, өвчин эмгэгтэй хүмүүст өглөх өгөх, ер нь аллах бурханыг шүтэн бодож өглөг өгч буян үйлдэх явдал юм. Эл зан үйлд монолын казахууд хэрхэн хандаж байна вэ гэвэл тэдний ихэнхи нь ямар нэг хэлбэрээр өглөг өгдөг нь ажиглагдаж байна. Гэхдээ тийнхүү өглөг өгөхдөө хэлбэрийн талаасаа тийнхүү ислам шашны шаардлага, зан үйлийг гүйцэтгэж байгаа гэх боловч яг өглөг өгч буй шалтгаан, сэдлийн хувьд арай өөр зүйл ажиглагдаж байгаа тал бий.

Эдүгээ үед Христын шашин, түүний байгууллагын зүгээс хуучны социалист байсан орнуудын хүн амын шүтэн бишрэх эрх чөлөөг хуулиар хамгаалж баталгаажуулсан, эдгээр оронд нийгмийн оюун санааны амьдрал, хүн ардын үзэл ухамсарт оршин үйлчилж байсан марксист-ленинист үзэл суртал халагдаж,түүний оронд бий болсон хоосон зайг эзлэх, христын шашны элдэв

олон урсгал чиглэлийг Монголд сурталчлан түгээн дэлгэрүүлэх оролдлого хийж байгаа билээ.

Тийм үйл ажиллагаа Баян-Өлгий аймагт ч хүрчээ. 1993 оны хавар Герман Улсаас Христос шашныг сурталчлан дэлгэрүүлэгчид Улаан загалмайн нийгэмлэгийн чиглэлээр тусламжийн бараа хүргэх хэлбэрээр эхлээд хүмүүсийн эрүүл мэндийг үзэх, өвчтөнүүдийг эмчлэх нэрээр тэдэнд Христос шашныг сурталчилж Библи судрыг Казах хэлээр тарааж, зураг хөрөг авчээ. Энэ үйл хэргийг Монголын мусульманы нийгэмлэгийн зүгээс эсэргүүцэж, олон нийтийн цуглаан зохиож холбооны салбарын чанга яригчийг хөлслөн авч эрс шийдэмгий няцааж, хөөн явуулж байлаа. Христос шашныг казахуудын дунд сурталчлах, дэлгэрүүлэх оролдлого 1998 онд дахин давтагдаж мөн адил ахиц ололтод хүрээгүй. Ер нь ислам шашин зөвхөн ганц Аллах бурханыг л шүтэхийг шаарддаг, энэ шашныг шүтэгчид өөр шашинд орох явдлыг Аллах бурханд урваж тэрсэлсэн хэрэг, нүгэл гэж үздэг. Нөгөөтэйгүүр цөөн тоотой казахууд ислам шашныг шүтэх явдал бол казах угсаатан байгаагийн нэг чухал шинж тэмдэг хэмээн үздэг учраас монголын казахууд өөр шашин шүтлэгт ордоггүй, ийм явдлыг шашин, сүм хийд төдийгүй эцэг эх, ах дүү, бусад хүмүүс эсэргүүцдэг онцлогтой. Гэхдээ казахууд нэг дор олон жил эв найртай хамтран аж төрж ирсэн адилхан эсгий туургатай урианхай, дөрвөд, тува ястнуудын бурханы шашин, сүсэг бишрэлийг хүндэтгэж ирсэн ба тэднийг хавчиж гадуурхсан, шашнуудын хооронд зөрчил сөргөлдөөн гарсан тохиолдол гараагүй байна.

Ислам шашин сэргэж цаашид өрнөж байгаа үйл явцын нэг салшгүй хэсэг, чиглэл бол шашны боловсрол, мэдлэгээс хөндийрч төсөөрсөн хүн амын өргөн давхраанд шашны мэдлэг, боловсрол, зан үйлийг зохион байгуулалттайгаар түгээн дэлгэрүүлж сурталчилан таниулах явдал болж байна. Энэ нь зохих үр дүнд хүрч байна. Гэхдээ 1990-ээд оны эхэн үед шашны байгууллага, молла нар хүн амын өргөн давхрааны шашны үзэл ухамсар, зан байдлыг төлөвшүүлж нөлөөндөө байлгах төвшинд хараахан хүрээгүй байлаа.

Судалгаанаас үзэхэд ислам шашин казахуудын амьдрал, сүсэг бишрэлд харьцангуй түргэн сэргэж дэлгэрч байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал казахуудын шашин шүтлэгийн байдлыг тус орны бусад аймаг, бүс нутаг, угсаатан ястны шашин шүтлэгтэй харьцуулахад зарим онцлог шинж, өвөрмөц байдал ажиглагдаж байна. Шашны социологич С.Цэдэндамбын 1994 онд манай орны 8 аймаг, Улаанбаатар хотын 1800 хүнийг хамруулж хийсэн судалгаанаас үзэхэд Баян-Өлгий аймгийн хүн амын 83,5% нь шашин шүтлэгтэй байгаа нь сүм хийд, хурал номын газар ихтэй бусад аймгуудын хүн амын шашин шүтлэгийн төвшингөөс нэлээд дээгүүр байна (7).

Ислам шашин зонхилсон бүс нутгийн орнуудаас Монголын казахуудын энэхүү уламжлалт шашныг дахин сэргээж хүчтэй дэлгэрүүлж гүнзгийрүүлэх талаар чармайж байгаа боловч газар зүйн байршил хол, мөн казахуудын аж төрх ёс, соёл, хэл, зан заншил тэдгээр орнуудынхаас ялгаа онцлогтой байгаа гэх зэрэг хэд хэдэн хүчин зүйл тэдний нөлөөллийг саармагжуулж байгаа тал байна.

Тийнхүү Монголын казах иргэдийн амьдрал, оюун санаа, сүсэг бишрэлд ислам шашин өөрийн ёс жаяг, хэм хэмжээнийхээ дагуу дахин сэргэж, дэлгэрэн бэхжиж байна. Мусульман казахууд ислам шашины зан үйл, ариун үүрэг, гол баяр ёслолыг уламжлалаар нь баримтлан үйлдэж хэвшил болгож байна. Тухайлбал Коран сударыг уншиж цээжлэх, намаз мөргөл, мацаг барих, хажийн их мөргөл үйлдэх, өглөг өгөх, шашнаар тогтоосон татвар төлөх, рамадан сар шувтарсны ба хаж мөргөлийн дараах баяр ёслолыг өргөн тэмдэглэх боллоо.

Манай казах иргэд уламжлалт ислам шашнаа зохих ёс жаягаар нь, элдэв хэт шүтлэг, фанатик үзэл, хуучирч хоцрогдсон ёс заншил, шашны экстремизм, бусад шашинд сөрөг хандсан элдэв сөргөлдөөн, шашин хоорондын зөрчил гаргахгүйгээр хэвийн, амгалан тайван шүтэн баримталж байгааг энд тэмдэглэн хэлүүштэй. Тэд ислам шашныг хамгийн гол нь казах үндэстэн угсаатны нэгэн гол чухал шинж чанар, соёлын нэг салшгүй хэсэг болохынх нь хувьд эрхэмлэж байна. Казахуудын ислам шашин шүтлэг өөрийнхөө ёс жаягаар хэвийн байдлаар дэлгэрч зохих үүргээ биелүүлэхэд нэг талаас төр, засаг захиргааны байгууллагууд шашин шүтэлгийн үйл явц, асуудлыг тус улсын хэмжээнд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд чөлөөтэй байлгах, зохицуулан чиглүүлэх, нөгөө талаас хүн ард, шүтлэгтнүүд өөрсдөө ислам шашны зорилго, асуудал, зөрчил, дэлгэрэлтийн зарим бэрхшээлийг зохиомлоор дэвэргэлгүй, асуудалд бодитой, ухаалаг, үндэстэй хандах явдал чухал болно.

Манай оронд ислам шашин дахин сэргэж дэлгэрч байгаа явцад урьд нь байгаагүй, ажиглагдаагүй зарим шинэ үзэгдэл, үйл явдал гарч байгааг энд товч боловч авч үзвэл зохино. Тухайлбал ислам шашин манай орны хотон ястаны шашин шүтлэгийн амьдралд нөлөөлж сэргэн дэлгэрч байна. Энэ нь тодорхой үндэс шалтгаантай, ямар нэг хэмжээний уламжлалтай ажээ.

Хотон ястан нь Увс аймгийн Тариалан суманд оршин суудаг, 1990-ээд оны дунд үеийн тоо баримт ёсоор 900 гаруй өрх, 4,6 мянга орчим хүн амтай, түүхийн хувь тавилангаараа Монгол нутагт ирж суурьшаад 280 гаруй жил болжээ (4). Энэ хугацаанд хотон нар хөрш зэргэлдээх дөрвөд, баяд ястаны соёл, зан заншил, шашин шүтлэг, хэл, аж төрх ёстой ижилсэн уусах хандлагатай болсны зэрэгцээ үндэс язгуурын соёл, шашин шүтлэгийн үлдэцээ тодорхой хэмжээгээр хадгалж буй онцлогтой. Манай орны угсаатан судлагч эрдэмтэн С.Бадамхатан 1958 онд хотон ястаны дунд судалгаа хийж үнэтэй баримт материал цуглуулж ном бичсэн бөгөөд түүндээ хотон ястаны хэл яриа, зан үйл зэрэгт ислам шашны ул мөр хадгалагдаж байгааг тодорхой баримтаар гаргаж тавьсан байна (4).

1990 оноос манай оронд ислам шашин чөлөөтэй сэргэн дэлгэрэх болсноор нэг талаас хотонгуудын дотор үлдсэн зарим молла, мусульман сүсэгтэний санал санаачилга, нөгөөтэйгүүр манай ислам шашны байгууллага, зүтгэлтэн, имам нарын идэвх чармайлтын харилцан нөлөөлөл, үр дүнд хотон ястаны дунд ислам шашныг сэргээн дэлгэрүүлэх ажил, арга хэмжээ явагдан өрнөж байгаа юм. Тухайлбал тэдэнд ислам шашныг таниулж шүтүүлэх, Тариалан суманд исламын мечеть барьж байгуулах, хотон хүмүүсээс молла бэлтгэх, хотон хүүхдүүдийг Турк улс зэрэг ислам шашинтай орнуудад шашны болон иргэний боловсролын сургуульд суралцуулах зэрэг ажил хийгдэж зохих үр дүнд хүрч байна. Өдгөө хотон ястаны хүн ард өөрсдийнх нь уугуул шашин бол ислам байсныг ухааран ойлгож түүнийг сэргээж дангаар нь шүтэн баримтлах оролдлого, алхамууд хийж байна. Гэвч тэд мусульман болж ислам шашныг дангаар нь шүтэж баримтлах, аж төрөх ёс, зан заншил, ахуй амьдрал нь ислам шашны дагуу өөрчлөгдөж казах мусульманчуудтай адил болоход ихээхэн бэрхшээлтэй, харьцангуй урт удаан хугацаа шаардагдах нь тодорхой байна.

Манай оронд ислам шашин сэргэн дэлгэрч байгаа хийгээд христийн шашны олон янзын урсгал орж ирж хүн ардад нөлөөлөх явцад тува, урианхай, дөрвөд түүнчилэн халх ястаны зарим хүн ислам шашинд орох тохиолдол гарч байгааг тэмдэглэвэл зохино. Гэвч энэ нь нийтлэг биш, үндсэндээ тохиолдолын шинжтэй байна.

Эл өгүүлэлд авч үзсэн асуудлын тоймыг нэг үгээр товч дүгнэж хэлбэл ислам шашин Монгол Улс дахь шашин шүтлэгийн нэгэн хэсэг болж дахин сэргэж эдүгээ өөрийн ёс жаягаараа дэлгэрч, сүм хийд, хурал ном, шашны сургалт хүмүүжил, хүмүүнлэг хийгээд материаллаг бааз суурь, аж ахуй, санхүү, гадаад харилцааны хувьд бэхжиж цаашид казах мусульманчуудын амьдралд баттай гүнзгийрэн өрнөх хандлага бүхий төлөвтэй байна.

Резюме

В статье автором рассмотрен вопрос о возрождении и нынешнем состоянии ислама в Монголии. Ислам в Монголии главным образом исповедуют казахи, а также определенная часть хотонов, проживающих в Увснурском аймаке.

В октябре 1990 г. было создано Монгольское исламское общество. Основные направления его деятельности: защита интересов монгольских мусульман, налаживание связей с исламскими организациями, поиск средств на возрождение ислама в Монголии. В стране ныне действует 38 мечетей. Идет налаживание системы религиозного образования, создание необходимой материальной основы мечетей. Для монгольских мусульман практически не характерны радикальные и экстремистские настроения.

Ном зүй

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992.
2. Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль. "Ардын эрх" сонин. 1993. 02. 30. № 196 (696)
3. Зарим сүм хийдийг сэргээн хамгаалахтай холбогдсон асуудлын тухай. БНМАУ – ын АИХ – ын Тэргүүлэгчидийн тогтоол. 1990. 02. 22. № 10. – БНМАУ – ын хууль, зарлиг, тогтоолын эмхэтгэл. 1990. №4
4. Бадамхатан С. Увсын хотон ястан. Эрдэнэт, 1995
5. Жамбал А. Ислам шашин. УБ., 2005
6. Хөдөлмөрчидийн шашингүйн хүмүүжилийн өнөөгийн асуудал. УБ., 1985
7. Цэдэндамба С. Монгол Улс дахь шашны нөхцөл байдал (XX – XXI зууны зааг үе) УБ., 2003.
8. Батырбек Х. Ораза, Намаз, Жаназа үкімдері. УБ., 2005
9. Быкумар К. Монголиадагы казактардын салт – дэстүрлері (Монгол Улс дахь казакуудын ёс заншил, уламжлал). Өлгий, 1995
10. Быкумар К. Казага катысты діни (Нас баралттай холбоотой шашны ёс заншил, уламжлал ба ойлголтууд) Өлгий, 2004
11. Куран Карим (Казакша магына және түсінігі) (Коран. Казахчилсан утга ба тайлбар. Араб хэлнээс казахчилсан Халифа Алтай). Медине хот, 1991.